



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐1᠕ оны ᠐7 сарын ᠐᠘ өдөр

Дугаар А/410

Мандалговь

Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-а, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтууд, Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймаг, сум орон нутагт зохион байгуулагдаж байгаа хурдан морины уралдаан, бооцоот уралдаан, мялаалганы найрны уралдаан, уулын тахилганы уралдаан, уралдааны өмнөх үсэргээ, сунгаанд уралдаанч хүүхдийг хамгаалалтын хувцас, хэрэгсэлгүйгээр уралдаанд оролцуулахыг хориглосугай.

Хоёр. Хурдан морины уралдаанч хүүхдэд “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага”-ыг хангасан хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсүүлж уралдаанд оролцуулж ажиллахыг “Нарны хүлэг” морин спорт уяачдын холбоо /Ц.Ганхүү/, сумдын уяачдын холбооны тэргүүн болон сумдын Засаг дарга, хамтарсан багт тус тус үүрэг болгосугай.


Гурав. Уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах стандарт шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж, уралдаанч хүүхдийн эрүүл мэнд, амь насыг хамгаалан, аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Цагдаагийн газар /Б.Очирдорж/, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар /Ц.Ганзориг/, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /Г.Хишигдаваа/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтийг жил бүрийн 05 дугаар сарын 2-ны өдрөөс 10 дугаар сарын 31-ний хооронд зохион байгуулагдсан хурдан морины уралдаан, бооцоот уралдаан, мялаалганы найрны уралдаан, уулын тахилганы уралдааны мэдээ, тайланг нэгтгэж 11 дүгээр сарын 10-ны дотор Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар /Ц.Ганзориг/-т ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, тайлан мэдээг нэгтгэж, танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Ц.Эрдэнэсүрэн/-т даалгасугай.

Тав. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай” А/410 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0208708